БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Аудитын код: БНА-2020/22/СТА-ТШЗ**

Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас:70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэзням

Утас:70444470 Цахим хаяг:

Аудитор:Д.Энхтуяа

Утас: 99449299 Цахим хаяг: tomoo_etuya@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга


Аудитын гэрчилгээ .......... 3

Аудитын тайлан .......... 4

2.1. Оршил .......... 5

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .......... 5

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .......... 5

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .......... 5

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .......... 6

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .......... 6

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .......... 6

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .......... 6

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .......... 7

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .......... 8

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .......... 8

2.13. Шилэн дансны мэдээлэл .......... 8

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .......... 9

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .......... 9

3.Менежментийн захидал .......... 10

4.1.Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан .......... 12

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... 12

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 14

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 17

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 17

4.6.Аудитлагдсан нэмэлт санхүүжилтийн тайлан .......... 19




005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.02.27 № 1/245

танай ____________ -ны №____________ -т

БАЯНЛИГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ С.ЦЭДЭНДОРЖ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянлиг Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020230

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал С.Цэдэндоржтанд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасаншийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэгаудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.21-нээс 2020.02.23–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Глобал капитал аудит ХХК-ны аудитор Д.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Глобал капитал аудит ХХК-т 2019.12.11-ны өдрийн 84тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго,үйлажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь " Суралцагчдын сурлагын ахиц амжилтыг дээдлэн,сурах арга барил,төлөвшил хандлагыг эрхэм болгож олон нийтийн оролцоог дэмжихэд оршино" гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах
- Чанартай,хүртээмжтэй, ахицтай боловсролын үйлчилгээг хүргэх
- Багш,сурагч солилцоо хөтөлбөр боловсруулан ажиллах
- Эцэг эх,олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх
- Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэн ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуульнь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандСанхүүгийн тооцоолох ХХК-ны Acolouc программ хангамж ашигладаг байна.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсонбөгөөд материаллаг байдлын суурьүзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг"Их"гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 148373,1 мянган төгрөгөөс тооцон 29674,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 29674,4 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 167059,3 мянган төгрөгөөр буюу 3,2 %-иар хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэнхөрөнгө дансны үлдэгдэл 181337,7мянган, бараа материалын дансны үлдэгдэл 17452,5 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсанбайна.


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 3,337.9 | 167.1 | (3,170.8) |
| Бараа материал | 74,556.1 | 92,008.6 | 17,452.5 |
| Үндсэн хөрөнгө | 5470839,6 | 5501529,4 | 30689,7 |
| Хуримтлагдсан элэгдэл | -301738,9 | -513766,4 | -212027,5 |
| **Нийт хөрөнгө** | **5,246,994.9** | **5,079,938.8** | **(167,056.1)** |
| Өр төлбөр | | 3.2 | 3.2 |
| Засгийн газрын оролцоо /Өздийн өмч/ | 5,246,994.9 | 5,079,935.60 | (167,059.3) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **5,246,994.9** | **5,079,938.8** | **(167,056.1)** |

Авлага өмнөх оноос 3170,8 мянган төгрөгөөр буурсанч167,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан ба энэ нь ажиллагсадтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд 73475,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь хандиваар 18543,9 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 54932,0 мянган төгрөгийн хөрөнгө авсныг орлогод бүрэн авсан ба буурсанньБаянлиг сумын ИТХТ-чдийн 2019.05.20-ны 16 тоот тогтоолоор 42486,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 17452,4 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн болон тусгай зориулалтын материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд 167056,1 мянган төгрөгөөр тайлант хугацааны үр дүнгийн өөрчлөлтөөр нэмэгдсэн байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1271234,6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1271234,6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 1039348,9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, Орон нутгийн төсвөөс 231885,7 мянга санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1260294,0 мянган төгрөг буюу 99,1 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 10940,5 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

**Нэмэлт төсөв**: Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 29982.1 мянган төгрөг орсон ба 13458.6 мянган төгрөгийг тэтгэмжийн зардалд, 10200.0 мянган төгрөгийг тэтгэлэгт хөтөлбөрийн зардалд, 3337,9 мянган төгрөгийг урсгал засварт тус тус зарцуулж ,2985,5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорилхэрэгжүүллээ.

Аудитаар нийт 22730,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 22479,3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага , 250,7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо. .

Аудитаар залруулагдаагүй алдаа зөрчилд албан шаардлага , төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Тус сургуулийн захирлын 2019.12.25-ний өдрийн А/49тоот тушаалаар тооллогын комисс томилогдож , тооллого хийсэн боловч үндсэн ба барааматериалын үлдэгдэл санхүүгийн тайлан , тооллогын бүртгэлээс 22479,3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.
   Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4 –т" Эд хөрөнгийн тооллого хийх,үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч , худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах " гэсэн заалтыг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Албан шаардлага өгөв.

2. Ажилтан Г.Болдтөрт 2019 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн Б/43 тоот тушаалаар сахилгын арга хэмжээ авсан атлаа 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд 250768 төгрөгийг олгосон байна.
   Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 тоот тогтоолоор батлагдсан , " Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам" –ын 4.3 дахь заалтыг тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар цалинг санхүүгийн программаар бодох, өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах , нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулж мөрдөөгүй зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нягтлан бодогч Ц.Төмөрчөдөрийг сургалтанд хамруулах талаар анхаарах

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараах байдалтай байна. Үүнд

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 2 | |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 28 | 8 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 84 | 12 | |
| | Нийт | 27 | 151 | 129 | 22 | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Шилэн дансны тухай хуулийн 6.1т заасны дагуу 3.1.1, 3.1.2 т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэсэн заалтыг зөрчиж 22 мэдээ, мэдээлэл хугацаа хоцроосон байна. Энэ нь тухай үүнээс сар бүрийн 8 мэдээнд өөрчлөлт оруулсаны улмаас хугацаа хоцорсон,тухай бүрийн мэдээн дээр 12, 7 сарын дээр сарын 8 мэдээ хоцорч оруулсан. 4 мэдээ засвар хийгдэж хоцорсон байна..

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

**“Зөрчилгүй” дүгнэлт**

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3.Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийнтайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн,дүгнэлтээс гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх ньтанай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

***1.1. <u>Илрүүлэлт:</u>***

Тус байгууллага нь Санхүүгийн Acolous программ ашиглаж байгаа болович санхүүгийн тайланд бүртгэлгүй байна.

***1.2. <u>Эрсдэл:</u>***

Биет бус хөрөнгийг бүртгээгүй байх,

**1.3. *<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Санхүүгийн программыг дахин үнэлж, хөрөнгөнд орлого авч санхүүгийн тайланг иж бүрэн цалин, анхан шатны тайланг хэвлэж, баталгаажуулж санхүүгийн программаар гаргах.

**1.4 <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

***<u>2.1. Илрүүлэлт:</u>***

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар Их халбагант ХХК, Баян-Аараг ХХКтай тооцоо нийлсэн акт байхгүй байна Энэ нь НББ-ын тухай хуулийн Энэ нь 19.1.4. "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэсэн заалтыг зөрчсөн



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

***2.2. Эрсдэл:***

Нягтлан бодох бүртгэлд өглөг авлага үндэслэлгүй нэмэгдэх, эд хөрөнгө дутагдах , шамшигдах

***2.3. Өгсөн зөвлөмж:***

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтыг мөрдөж, сар бүр бэлтгэн нийлүүлэгч , худалдан авагчидтай тооцоо нийлж , үлдэгдлийг батлагдсан маягтын дагуу тооцоо бодсон актаар баталгаажуулж байх

**2.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

**3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

***3.1. Илрүүлэлт:***

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын онцлог, үйл ажиллагааг тусгаж боловсруулсан жишиг бичиг баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавapт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана, 20 дугаар зүйлийн 20.2.2.-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

***3.2. Эрсдэл:***

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

***3.3. Өгсөн зөвлөмж:***

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавapт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталж, мөрдөж санхүүгийн үйл ажиллагаанд бүрэн хэрэгжүүлж ажиллах.

**3.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 77,894,165.90 | 92,175,837.57 |
| 33 | **АВЛАГА** | 3,337,999.98 | 167,188.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 167,188.00 |
| 335 | **Бусад авлага** | 3,337,999.98 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 3,337,999.98 | 00.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 74,556,165.92 | 92,008,649.57 |
| 351 | **Түүхий эд материал** | 4,344,356.54 | 13,682,856.54 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,344,356.54 | 13,682,856.54 |
| 354 | **Хангамжийн материал** | 65,561,809.38 | 73,675,793.03 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 349,110.00 | 559,110.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 65,212,699.38 | 73,116,683.03 |
| 35600 | Мал амьтад | 4,650,000.00 | 4,650,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 5,169,100,790.54 | 4,987,763,011.47 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 5,169,100,790.54 | 4,987,763,011.47 |
| 392 | **Биет хөрөнгө** | 5,128,970,790.54 | 4,947,633,011.47 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,954,145,331.02 | 4,983,045,331.02 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -72,663,992.64 | -262,695,444.48 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 15,500,000.00 | 15,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -7,965,277.86 | -10,548,611.22 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 260,653,664.14 | 235,205,654.14 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -145,952,677.48 | -151,123,927.34 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 177,899,615.20 | 204,445,366.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -75,156,924.84 | -89,398,409.85 |
| 39217 | Ном | 22,511,053.00 | 23,203,053.00 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 40,130,000.00 | 40,130,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 40,130,000.00 | 40,130,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 5,246,994,956.44 | 5,079,938,849.04 |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 3,244.00 |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 3,244.00 |
| 413 | **Өглөг** | 00.00 | 3,244.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 3,244.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 5,246,994,956.44 | 5,079,935,605.04 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,246,994,956.44 | 5,079,935,605.04 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 514,828,217.20 | 514,828,217.20 |
| 51101 | Өмч: - төрийн | 514,828,217.20 | 514,828,217.20 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 4,081,211,275.55 | 3,914,151,924.15 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,081,211,275.55 | 4,081,211,275.55 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -167,059,351.40 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 650,955,463.69 | 650,955,463.69 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 5,246,994,956.44 | 5,079,938,849.04 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-2А**

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,032,335,159.68** | **1,316,663,795.65** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,781,647.00** | **18,785,095.65** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 27,781,647.00 | 18,785,095.65 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 27,781,647.00 | 18,785,095.65 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,295,200.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 25,986,447.00 | 18,785,095.65 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **34,743,312.68** | **258,529,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 969,810,200.00 | 1,039,348,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 969,810,200.00 | 1,039,348,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,577,203.68 | 26,644,100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 23,658,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,577,203.68 | 2,985,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 231,885,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 231,885,700.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 24,166,109.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 24,166,109.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,168,859,077.08** | **1,482,365,405.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,168,859,077.08** | **1,481,871,405.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,074,924,729.40 | 1,422,741,444.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 581,933,473.00 | 743,598,302.00 |
| 210101 | Үндсэн цалин | 581,933,473.00 | 557,694,917.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 99,483,522.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 86,419,863.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 70,326,602.00 | 95,644,956.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,326,602.00 | 95,644,956.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 155,695,000.01 | 218,892,893.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,681,483.00 | 5,500,533.00 |
| 210302 | Түлш, халаалт | 150,013,517.01 | 212,612,360.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 780,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,895,016.20 | 22,105,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,727,388.00 | 8,250,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,969,020.00 | 5,363,920.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 65,000.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 30,000.00 | 15,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 3,255,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 952,620.00 | 5,156,180.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,215,988.20 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 61,195,350.00 | 58,248,155.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 277,600.00 | 483,990.00 |
| 210502 | Хоол, хүнс | 58,515,950.00 | 56,278,165.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,401,800.00 | 1,486,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,867,800.00 | 15,334,999.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,867,800.00 | 15,334,999.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 550,500.00 | 2,473,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 550,500.00 | 2,473,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,907,600.00 | 3,522,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,907,600.00 | 3,522,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 181,553,388.19 | 262,920,939.23 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 229,000.00 | 5,425,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,200,000.00 | 4,040,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 167,124,388.19 | 253,455,939.23 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 93,934,347.68 | 59,129,960.98 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 89,806,909.00 | 45,203,900.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 24,166,109.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,878,600.00 | 31,325,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,887,600.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,224,600.00 | 13,458,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 650,000.00 | 420,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,337,999.98 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,337,999.98 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 9,481,307.98 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 6,495,807.00 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 2,985,500.98 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 789,438.70 | 4,444,753.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 789,438.70 | 4,444,753.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **494,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 494,000.00 |
| 221001 | Их засвар | 00.00 | 494,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-136,523,917.40** | **-165,701,609.56** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 891,774,105.79 | 1,357,741.84 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 1,357,741.84 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 891,774,105.79 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -891,774,105.79 | -1,357,741.84 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,028,298,023.19** | **-167,059,351.40** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,006,348,712.68** | **1,303,094,942.98** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,795,200.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,795,200.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,795,200.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,295,200.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,004,553,512.68** | **1,303,094,942.98** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 969,810,200.00 | 1,039,348,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 969,810,200.00 | 1,039,348,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,577,203.68 | 29,982,099.98 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 26,996,599.98 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,577,203.68 | 2,985,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 231,885,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 231,885,700.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 24,166,109.00 | 1,878,243.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 24,166,109.00 | 1,878,243.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,006,348,712.68** | **1,303,094,942.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,006,348,712.68** | **1,303,094,942.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **912,414,365.00** | **1,238,988,839.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 581,933,473.00 | 743,598,302.00 |
| 210101 | Үндсэн цалин | 482,823,973.00 | 557,694,917.00 |
| 210102 | Нэмэгдэл | 72,966,900.00 | 99,483,522.00 |
| 210104 | Урамшуулал | 26,142,600.00 | 86,419,863.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 70,326,602.00 | 95,808,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,352,502.00 | 71,628,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,737,142.00 | 6,065,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,897,500.00 | 4,926,932.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 974,700.00 | 1,207,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,364,758.00 | 11,980,668.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 155,695,000.00 | 218,892,893.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,681,483.00 | 6,464,393.00 |
| 210302 | Түлш, халаалт | 150,013,517.00 | 211,648,500.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 780,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,346,120.00 | 16,073,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,890,280.00 | 5,562,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,198,820.00 | 6,155,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 65,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 642,000.00 | 1,732,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,615,020.00 | 2,378,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 60,032,950.00 | 64,399,255.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 277,600.00 | 776,990.00 |
| 210502 | Хоол, хүнс | 58,515,950.00 | 59,303,165.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,239,400.00 | 4,319,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,867,800.00 | 67,506,800.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 16,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,867,800.00 | 51,506,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 550,500.00 | 2,473,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 550,500.00 | 2,473,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,460,900.00 | 14,542,499.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,460,900.00 | 14,142,499.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 31,201,020.00 | 15,694,190.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,131,020.00 | 7,940,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,070,000.00 | 7,754,190.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **93,934,347.68** | **64,106,103.98** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 89,806,909.00 | 50,180,043.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 24,166,109.00 | 1,878,243.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,878,600.00 | 31,325,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,887,600.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,224,600.00 | 13,458,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 650,000.00 | 3,517,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,337,999.98 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,337,999.98 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 9,481,307.98 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 6,495,807.00 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 2,985,500.98 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 789,438.70 | 4,444,753.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 789,438.70 | 4,444,753.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 474,698,217.20 | 00.00 | 5,094,471,298.76 | 5,569,169,515.96 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 474,698,217.20 | 00.00 | 5,094,471,298.76 | 5,569,169,515.96 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 40,130,000.00 | 00.00 | -1,028,298,023.19 | -988,168,023.19 |
| C08 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 514,828,217.20 | 650,955,463.69 | 4,081,211,275.55 | 5,246,994,956.44 |
| D01 | 2019оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 514,828,217.20 | 650,955,463.69 | 4,081,211,275.55 | 5,246,994,956.44 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 514,828,217.20 | 650,955,463.69 | 4,081,211,275.55 | 5,246,994,956.44 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -167,059,351.40 | -167,059,351.40 |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **514,828,217.20** | **650,955,463.69** | **3,914,151,924.15** | 5,079,935,605.04 |

## 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 932,864,800.00 | 932,564,800.00 | 1,271,234,600.00 | 1,260,294,040.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 932,864,800.00 | 932,564,800.00 | 1,271,234,600.00 | 1,260,294,040.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 831,918,400.00 | 831,618,400.00 | 1,236,287,600.00 | 1,225,450,840.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 548,280,500.00 | 548,280,500.00 | 745,319,200.00 | 743,598,302.00 |
| 210101 | Үндсэн цалин | 441,794,500.00 | 441,794,500.00 | 558,250,000.00 | 557,694,917.00 |
| 210102 | Нэмэгдэл | 61,172,300.00 | 61,172,300.00 | 100,428,100.00 | 99,483,522.00 |
| 210104 | Урамшуулал | 45,313,700.00 | 45,313,700.00 | 86,641,100.00 | 86,419,863.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,421,700.00 | 60,421,700.00 | 95,808,900.00 | 95,808,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,421,700.00 | 60,421,700.00 | 71,548,300.00 | 71,628,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 6,065,100.00 | 6,065,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 4,852,000.00 | 4,926,932.00 |
| 210204 | Ажилгүйдлийн | 00.00 | 00.00 | 1,213,300.00 | 1,207,700.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | даатгал | | | | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 12,130,200.00 | 11,980,668.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 126,657,200.00 | 126,422,203.00 | 225,385,700.00 | 218,892,893.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,097,200.00 | 6,302,721.00 | 8,197,200.00 | 6,464,393.00 |
| 210302 | Түлш, халаалт | 116,360,000.00 | 119,627,448.00 | 216,408,500.00 | 211,648,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,200,000.00 | 492,034.00 | 780,000.00 | 780,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,338,100.00 | 10,338,100.00 | 16,119,200.00 | 16,073,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,312,300.00 | 2,482,800.00 | 5,294,600.00 | 5,562,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,008,000.00 | 4,008,000.00 | 6,170,000.00 | 6,155,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,556,500.00 | 1,782,100.00 | 359,400.00 | 65,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 493,500.00 | 433,000.00 | 1,734,400.00 | 1,732,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 180,000.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,967,800.00 | 1,632,200.00 | 2,380,800.00 | 2,378,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 58,664,100.00 | 58,626,895.00 | 66,569,800.00 | 64,399,255.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 539,300.00 | 539,300.00 | 785,800.00 | 776,990.00 |
| 210502 | Хоол, хүнс | 57,185,200.00 | 57,147,995.00 | 61,461,400.00 | 59,303,165.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 939,600.00 | 939,600.00 | 4,322,600.00 | 4,319,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,019,100.00 | 4,005,302.00 | 67,509,800.00 | 67,506,800.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 | 16,000,000.00 | 16,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,019,100.00 | 4,005,302.00 | 51,509,800.00 | 51,506,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,013,000.00 | 999,000.00 | 2,580,000.00 | 2,473,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,013,000.00 | 999,000.00 | 2,580,000.00 | 2,473,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 972,200.00 | 972,200.00 | 1,201,600.00 | 1,004,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 972,200.00 | 972,200.00 | 801,600.00 | 604,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 | 400,000.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21552500.00 | 21552500.00 | 15793400.00 | 15694190.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,552,500.00 | 21,552,500.00 | 8,000,000.00 | 7,940,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 00.00 | 7,793,400.00 | 7,754,190.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 100946400.00 | 100946400.00 | 34947000.00 | 34843200.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 100,946,400.00 | 100,946,400.00 | 34,947,000.00 | 34,843,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 32,522,200.00 | 32,522,200.00 | 31,420,500.00 | 31,325,300.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗЭРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 52,237,700.00 | 52,237,700.00 | 00.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,186,500.00 | 16,186,500.00 | 00.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 00.00 | 3,526,500.00 | 3,517,900.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 933,313,700.00 | 933,064,800.00 | 1,271,234,600.00 | 1,260,294,040.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 932,813,700.00 | 932,564,800.00 | 1,039,348,900.00 | 1,034,904,147.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 932,813,700.00 | 932,564,800.00 | 1,039,348,900.00 | 1,034,904,147.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 231,885,700.00 | 225,389,893.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 00.00 | 231,885,700.00 | 225,389,893.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 500,000.00 | 500,000.00 | 00.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 500,000.00 | 00.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 66 | 68 | 66 | 68 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 51 | 53 | 51 | 53 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 14 | 14 | 14 | 14 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 745 | 745 | 745 | 745 |

## 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**НТ-2**

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,577,203.68** | **29,982,099.98** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 10,577,203.68 | 29,982,099.98 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **10,577,203.68** | **29,982,099.98** |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,577,203.68** | **29,982,099.98** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 13,537,999.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 13,458,600.00 |
| 213404 | Төвлөрлүүлэх шилжүүлгэ | | 2,985,500,98 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 26,996,599.98 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,577,203.68 | 2,985,500.98 |
| **1310** | **НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **10,577,203.68** | **29,982,099.98** |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:АУДИТОР Д.ЭНХТУЯА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.27



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ